

## “АРД ИНВЕСТМЕНТ ГРУПП” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№26/01

**Огноо:** 2026 оны 4 сарын 29

**Цаг:** 15:00

**Байршил:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр, 17 давхар, Криптос ресторан

“Ард Инвестмент Групп” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 15:00 цагт нээв.

### ХУРАЛ НЭЭВ

**Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:** Сайн байцгаана уу, юун түрүүнд Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ энэхүү өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн Ард Инвестмент Групп ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан тооллогын комиссын эрх, үүргийг хэрэгжүүлэхээр Ард Секюритиз УЦК ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Бямбагэрэл миний бие Тооллогын комиссын даргаар, тооллогын комиссын гишүүнээр мөн компанийн дилер Ч.Даваацэрэн мөн компанийн хуулийн зөвлөх Б.Эрдэнэбилэг нар томилогдон ажиллаж байна. Хурлын дэгийн дагуу хурлын ирцийн мэдээллийг та бүхэнд хүргүүлье. Ард Инвестмент Групп ХК нь нийт 86,707,294 ширхэг хувьцаа гаргасан байна. Үүнээс 81,372,994 ширхэгийн хувьцаа саналын эрхтэй байгаагаас өнөөдрийн хуралд 75,291,529 ширхэг буюу 92.53 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид энэхүү хуралд оролцож байна. Иймд, Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү хурал хүчин төгөлдөр болно. Тооллогын комисс.

Ийнхүү Хурлын дэгийн дагуу Ард Инвестмент Групп ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Батбаярыг урьж байна.

**П.Батбаяр:** Сайн байцгаана уу, Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл болон тооллогын комиссын гишүүддээ баярлалаа. Тооллогын ирцийн дүнг та бүхэн харлаа. Хангалттай ирц бүрдсэн тул хурлын үйл ажиллагааг албан ёсоор нээснийг мэдэгдье. Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх дараах асуудлуудыг бид бэлдсэн байна. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхнээс хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой ямар нэг санал байна уу. Байхгүй байгаа тул хэлэлцэх асуудалдаа оръё.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ №1

Ард Инвестмент Групп ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

**П.Батбаяр танилцуулав:** Юуны өмнө хөрөнгө оруулалтын багцаа та бүхэнд танилцуулъя. AIGroup (Ард Инвестмент Групп ХК) буюу хуучнаар Хөвсгөл ХК гэж байсан. Бид энэ

хувьцаат компанийн хувьцааг өнгөрсөн жилээс эхлэн худалдан авснаар голлох хувьцаа эзэмшигч болсон.

Энэ компанийн хүрээнд бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн багцад байгаагаас бусад компаниудын үйл ажиллагааг төвлөрүүлж байгаа. Үүнд ТэнГэрЛиг Медиа Групп ХК, Монгол ТВ, ТэнГэр ТВ, Unread Media зэрэг охин компаниуд багтана. Мөн Крипто Үндэстэн, Монгол Дифай, Мета Форс зэрэг компаниуд ч хамаарна. Та бүхэн өмнөх хурлуудын хүрээнд эдгээр компаниудын талаар тодорхой ойлголтод хүрсэн болов уу гэж бодож байна.

ГрэйпСити нь програм хангамж болон санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компани бөгөөд үүнд Мост Финтек, NSP зэрэг компаниуд багтдаг. Иксгрупп ХХК-ийн дор Улаанбаатар үнэт цаасны бирж буюу Монгол Улс дахь хоёр дахь хувийн биржийн үйл ажиллагааг эрхэлдэг компани орж байна. Түүнчлэн Айдакс крипто бирж ажиллаж байгаа бөгөөд хамгийн сүүлийн Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан мэдээллээр нийт крипто арилжааны 50 гаруй хувь нь дангаараа Айдакс биржээр дамжиж байна гэж ойлгож байгаа. Лотто нь та бүхэн бүтэн сайн өдөр бүр Монгол телевизээр үздэг сугалааны тохирлын үйл ажиллагаа явуулдаг компани юм.

Ийм хөрөнгө оруулалтын бүтэцтэй бөгөөд цаашдын зорилго нь нэгдүгээрт, санхүүгийн бус салбарт “Баялагтаа эзэн Монгол” гэсэн уриатайгаар эрчим хүч, хариуцлагатай уул уурхайг дэмжих платформ болох юм. Түүнчлэн Smart City буюу ухаалаг хотын төслүүдийг дэмжин ажиллахаар зорьж байна. Энэ хүрээнд сүүлийн нэг жилийн хугацаанд нэлээдгүй ажил хийгдсэн.

#### 2025 оны онцлох хэлцлүүд

Дээр дурдсанчлан Ард Инвестмент Групп ХК нь сэргээгдэх эрчим хүчний салбарт төсөл хэрэгжүүлж эхэлж байгаа бөгөөд хариуцлагатай уул уурхайг дэмжих чиглэлээр ажиллана. Гэхдээ бид уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч биш, харин эдгээр компаниудыг дэмжих платформ юм.

Монгол Улсын ДНБ-ийн 25 хувь, экспортын 90 гаруй хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг боловч энэ салбарын талаар үнэн зөв, бодит ойлголт олон нийтэд харилцан адилгүй байдаг. Үүнд олон шалтгаан бий. Хариуцлагагүй уул уурхай, төрийн өмчит компаниудын зарим буруу шийдвэр, мөн төсөл хэрэгжиж буй бүс нутгийн иргэдтэй ойлголцол дутмаг байх зэрэг асуудлууд оршдог.

Иймд бид хариуцлагатай уул уурхайн компаниудад санхүүгийн шийдэл гаргахад нь дэмжлэг үзүүлэх, мөн орон нутгийн иргэдэд төслөө зөв, ил тод танилцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллахад бэлэн байна.

Мөн дөнгөж өчигдөр бид Монголын хөрөнгийн биржийн гуравдугаар ангилалд бүртгэлтэй Хүннү Менежмент ХК-д хөрөнгө оруулалт хийхээр болсон. Энэ нь Улаанбаатар хотын

түгжрэл, эрчим хүчний асуудлыг уул уурхай, эрчим хүч, ухаалаг хотын төслүүдтэй уялдуулан шийдэх зорилготой.

AIGroup-ийн гол зорилго нь “Баялагтаа эзэн Монгол” буюу Монголчууд өөрсдийн баялагтаа эзэн байх зорилгыг хэрэгжүүлэхэд оршино гэж ойлгож болно. Хүннү Менежменттэй байгуулсан төслийн хүрээнд:

Хүнд даацын автомашины батерей солих төсөл

Нэгдсэн удирдлагын төв байгуулах

Цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэх цэгүүдийг байгуулах

Тээврийн аюулгүй, баталгаат байдлыг хангах

Цахилгаан авто тээврийн засвар үйлчилгээний төв байгуулах зэрэг ажлуудыг эхний ээлжид хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Дараагийн шатанд эрчим хүчний шинэ эх үүсвэр, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлд ажиллана гэж харж байна.

Хоёр дахь хэлцэл нь хариуцлагатай уул уурхайг дэмжих төсөл бөгөөд Степ Нэксус МКЕ ХХК-тай холбоотой. Тус компани нь Төв аймгийн Баянжаргалан суманд нүүрс болон бордооны үйлдвэр байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд үнэгүй хувьцаа олгох, мөн хариуцлагатай уул уурхайн талаар зөв мэдээлэл түгээх зорилготой. Энэ хүрээнд Ард Секюритиз ҮЦК ХХК-тай хамтран ажиллахаар болсон бөгөөд одоогоор нарийвчилсан хяналтын ажил хийгдэж байна. Амжилттай хэрэгжсэн тохиолдолд дараагийн шатны гэрээнүүдийг байгуулж хамтын ажиллагааг эхлүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл нь нээлттэй компанийн хувьд 9 гишүүнтэй байх шаардлагатай.

ТУЗ-ийн даргаар миний бие П. Батбаяр ажиллаж байна. Би өмнө нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, даргаар ажиллаж байсан бөгөөд Resilience Mongolia Mining ХХК-ийн үүсгэн байгуулагч юм.

Ердийн гишүүд:

Ч. Ганхуяг – Ард Инвестмент Групп ХК-ийн Гүйцэтгэх захирал

Х. Билгүүн – Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Н. Эрдэнэтулга – Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал

Бруно Рашле – Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн томоохон хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн

Хараат бус гишүүд:

Васа Серпт – Algotech Srbija-ийн Гүйцэтгэх захирал

Ч. Мөнхбат – SouthGobi Sands ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Г. Зол-Эрдэнэ – Red Star Club ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Мөн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Б. Золбоо нь гэр бүлийн бизнестээ анхаарах зорилгоор ТУЗ-ийн гишүүний үүргээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөнтэй холбоотойгоор өмнөх долоо хоногийн баасан гарагт буюу 2026 оны 4 дүгээр сарын 24-ний ээлжит хурлаар хараат бус гишүүнийг шинээр томилсон.

Ингэснээр Ард Инвестмент Групп ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Голланд улсын иргэн, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигч Корнелус Якобус Мостерд томилогдсон байна.

**Ч.Ганхуяг танилцуулав:** Та бүхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож буй явдалд талархал илэрхийлье. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаагаа халааслуулаад Хөвсгөл ХК-ийн хувьцааг эзэмшиж орж ирсэн явдалд миний бие хувь хүний хувьд мөн энэ компанийн удирдлагийн багийн гишүүний хувьд та бүхэнд талархал илэрхийлье. Манай компани дөнгөж ажлаа эхэлж байгаа, 100-200 хүртэлх хувьцаа эзэмшигчид идэвхтэйгээр орж ирсэн байна. Өнөөдрөөс бид хувьцааны үнэ ханшдаа анхаарч, шинэ төслүүдийг хэрэгжүүлж эхэлнэ. Компанийн гарааны баланс харагдаж байна. Энэ жилийн эхний улиралд манай компани үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх хэмжээнд орлогоо олж явсан. Өмнө жилийн хувьд бид орлогогүй байсан. Эхний Төлөөлөн удирдах зөвлөлийн баг өмнө жилийн хоёрдугаар хагаст батлагдаж орж ирснийг Батбаяр дарга өмнө танилцууллаа. Компанийн удирдлагын баг мөн бүрэлдэж эхэлж байна. Тухайлбал, компанийн нягтлан бодогчоор Б.Уянга, Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар А.Азбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар О.Нандинцэцэг, Хууль, эрх зүйн нийцлийн асуудлыг Ө.Ашхүү нар хариуцан ажиллахаар болсон байна. Нийт зардалд эх үүсвэрийн хүүний зардал бичигдсэн байна. Манай баланс хураангуй байдлаар орсон байна. Дэлгэрэнгүй байдлаар Монголын хөрөнгийн биржийн сайтаас олж үзэх боломжтой тул та бүхэн асуулт байвал ирүүлэх боломжтой. Бид 36 тэрбум төгрөгийн баланстай болсон. Үүнд юу багтаж байгаа талаар буюу хөрөнгө оруулалтын багцыг өмнө Батбаяр танилцуулсан. Бид та бүхнийхээ өмнөөс хөрөнгө оруулалт хийж байгаа, үүнийг яаж санхүүж байгаа вэ гэдэгт өр төлбөр орж байна. Үүнийхээ үр дүнд тодорхой хүү, төлбөр төлж байгаа гэсэн үг. Сайн мэдээ нь бид зардлаа орлогоороо нөхөж ажилласан. Цаашдаа уул уурхайн төслөөс ногдол ашиг орж ирэх, жишээ нь Айдакс бирж ногдол ашиг 7 жилийн дараа хуваарилсан зэргээр урт хугацаанд үр дүн гаргаж явна. Бид 22 тэрбум төгрөгийн өр төлбөрөө хэрхэн барагдуулах вэ гэдэг асуулттай нүүр тулна. Үүнд А.Азбаяр захирал хариуцан ажиллахаар орж ирсэн байна. Бидний өмнө хийсэн хөрөнгө оруулалтууд 30 гаруй компанийн тодорхой хэсгийг стратегийн хөрөнгө оруулагч нарт худалдаж эхэлнэ. Тухайлбал, бид ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн 20 хувийг 5 сая ам.доллар буюу 18 тэрбум төгрөгөөр зарахаар ажиллаж байна.

Ард Менежмент компанийн тайланг танилцуулъя. Ард Менежмент компани маань 2011 онд үүсгэн байгуулагдсан, 2016 онд санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө авсан. Ард Менежмент компани маань нийт 2 сан удирдаж байна. 2020 онд Монголын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний хувьчлалын санг үүсгэн байгуулсан. Сангийн хувьд 2020 оны 10 сард үүсгэн байгуулагдаад 2021 оны 2 сар гэхэд нэгж эрхийн зах зээлийн үнэлгээ 750 төгрөг хүртэл өссөн, өндөр өсөлт үзүүлж байсан түүхтэй. Улмаар хөрөнгө оруулалтын санг эрэлт хэрэгцээтэй байна хэмээн үзэж Хөрөнгө оруулагч үндэстэн санг 2022 онд үүсгэн байгуулснаар хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сангийн онцлогийн хувьд Монголын хөрөнгийн бирж болон бусад хөрөнгийн биржүүдээр арилжаалагддаггүй, зөвхөн Ард аппаар дамжуулан арилжаалагддаг сан байдаг. Мост, ГрэйпСити Монгол зэрэг компаниудад бид тус бүр 45 хувьтай байгаад түүнийхээ тал талыг зарах зэрэг хэлцлүүд дээр ажиллаж байна. Айдакс ашигтай ажиллаж эхэлсэн тул бид гадныханд зарна зэргээр оруулсан хөрөнгө оруулалтуудаа нугалж байна. 2025 оны онцлох хэлцлүүд мөн ялгаагүй бид хувь авч орж байгаа. Оны сүүлээр бид мөн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа болон АрдКойн авсан. Тэгэхээр бид тусгаарлаж байгаа компанийнхаа мөн хувьцаа эзэмшигч болж байна.

Энэ хэсэгт томоохон хувьцаа эзэмшигчдийг харуулж байна. Бруно Рашле, Сүхдорж, Ганхуяг, Уянга зэрэг хүмүүс хувьцаагаа солиод орж ирсэн. Хувьцааны төвлөрөл эхний 10 хүнд байгааг харж байгаа байх. Би нэг жилийн өмнө Арл Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаагаа хөрвүүлж солих боломжтой байна гэж зарлаж байсан. Сольсон хүмүүс энд харагдаж байна. Өмнө жил 217 хүн хувьцаагаа солихоор шийдвэрлэсэн байна. Манай Нямбадраа ТООП-20 хувьцаа эзэмшигч дунд орж ирсэн байна г.м. Санхүүгийн тайлангийн хувьд ойлгомжтой байдлаар танилцуулахыг хичээлээ. Аудитлагдсан тайланг Б.Уянга танилцуулна.

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2

2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт

**Б.Уянга танилцуулав:** 2025 оны санхүүгийн тайланд Интер Аудит ХХК хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргасан. 2002 оноос эхлээд 23 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа аудитын байгууллага. Аудитын баг бүрэлдэхүүний хувьд нийт багаараа ажиллаад манай санхүүгийн тайланг тус үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, санхүүгийн байгууллагын тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тольлуулсан гэдэг стандарт дүгнэлтийг өгсөн.

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3

2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

**П.Батбаяр танилцуулав:** Ч.Ганхуяг захирал болон Б.Уянга нартаа баярлалаа. Өмнө хэлсэнчлэн бид түрүү жилээс эхлээд Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнтэй, 3 хороотойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Хороодын хувьд Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо болон Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо

гэсэн гурван хороодод хуваагдан ажиллаж байна. 2025 оны тайлант жилд Төлөөлөн удирдах зөвлөл нийт 3 удаагийн ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулж, мөн 3 удаагийн эчнээ санал хураалтын үр дүнд 17 асуудлыг шийдвэрлэсэн. Энэ хэсэгт хурлын нийт ирц болон хуралдсан огнооны талаарх мэдээллийг харуулж байна. 2025 оны 5 дугаар сараас эхлээд 2025 оны 12 дугаар сар хүртэл 6 удаагийн хурал, эчнээ санал хураалтыг зохион байгуулсан. Хурлын ирцийн хувьд 100 хувьтай, ирц өндөр байдгийг харж болно.

#### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4**

2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулдаг.

**П.Батбаяр танилцуулав:** Төлөөлөн удирдах зөвлөлөөс Ард Инвестмент Групп ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцаад:

Интер Аудит ХХК-ийн гаргасан 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулж, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Батбаярт даалгасугай гэсэн тогтоолын төслийг баталсан байна.

#### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №5**

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах

**П.Батбаяр танилцуулав:** Энд мэдээж ойлгомжтой болов уу. Бид үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй тухай 2026 оны 2 сарын 16-ны өдрийн 26/03 дугаар тогтоолоор холбогдох шийдвэр гарсан.

#### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №6**

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

**П.Батбаяр танилцуулав:** Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар оруулсан байгаа. Энд голлох заалтуудын хувьд бид эрхэм зорилго болон алсын хараагаа тодорхойлсон. Цаашид энэхүү дүрмийн төсөл батлагдсанаар бид Хөрөнгө оруулагч үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой, мөн эрчим хүч, ухаалаг хот, хариуцлагатай уул уурхайн төслүүдийг дэмжих замаар Баялагтаа эзэн Монгол байх алсын хараатай ажиллах болно.

#### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №7**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах

**П.Батбаяр танилцуулав:** Компанийн тухай хуулийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл тодорхой хэмжээний урамшуулал авах шаардлага үүсдэг. Бидний хувьд хамгийн бага төсвөөр цалин, урамшууллыг шийдэх гэж хичээж байна. Нийт 9 гишүүн байгаа бөгөөд компанийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбоотой сар бүр хуралдах, санал хураалт явуулах зэрэг шаардлага үүсэж байна. Улмаар дараах төсвийг батлуулахаар хэлэлцэх асуудалд суулгасан байна.

| (Төгрөг)                            | Улирал    | Жил        |
|-------------------------------------|-----------|------------|
| ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал | 7,500,000 | 30,000,000 |
| Нийт                                | 7,500,000 | 30,000,000 |

## САНАЛ ХУРААЛТ

**Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл**

Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Хэлэлцэх асуудал №1 – Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах тухай

Санал хураалтын дүн

| Нийт саналын эрхтэй хувьцаа | Зөвшөөрсөн |      | Татгалзсан |      | Түтгэлзсэн |      |
|-----------------------------|------------|------|------------|------|------------|------|
|                             | Тоо        | Хувь | Тоо        | Хувь | Тоо        | Хувь |
| 81,372,994                  | 75,291,529 | 100% | -          | -    | -          | -    |

**Хэлэлцэх асуудал №2 - Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай**

Санал хураалтын дүн

| Нийт саналын эрхтэй хувьцаа | Зөвшөөрсөн |      | Татгалзсан |      | Түтгэлзсэн |      |
|-----------------------------|------------|------|------------|------|------------|------|
|                             | Тоо        | Хувь | Тоо        | Хувь | Тоо        | Хувь |
| 81,372,994                  | 75,291,529 | 100% | -          | -    | -          | -    |

**Хэлэлцэх асуудал №3 - ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай**

Санал хураалтын дүн

| Нийт саналын эрхтэй хувьцаа | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түтгэлзсэн |
|-----------------------------|------------|------------|------------|
|-----------------------------|------------|------------|------------|

|            | Тоо        | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
|------------|------------|------|-----|------|-----|------|
| 81,372,994 | 75,291,529 | 100% | -   | -    | -   | -    |

Хурлаас гарсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг уншиж танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах тухай.

Хурал 17:00 цагт өндөрлөв.

Хянасан:

Хурлын дарга П.Батбаяр

*П.Батбаяр*

Тэмдэглэл хөтөлсөн:

О.Нандинцэцэг

*О.Нандинцэцэг*

